



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/298

Хэрлэн сум

Уулзалт зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн удирдлагууд төрийн бодлого шийдвэр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, цаг үеийн ажлын талаар орон нутгийн иргэдэд мэдээлэл хүргэх, тэдний санал хүсэлтийг сонсох уулзалт зохион байгуулахад 1,846,000 (нэг сая найман зуун дөчин зургаан мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010670



Аймгийн Засаг даргын 2022 оны
06 дугаар сарын 06 өдрийн
06 дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Томилолт	11 хүн 2 хоног	26,500x22	583,000
2	Шатахуун дизель	750 (1 машин) 150л	3,380	507,000
3	Шатахуун А-92	750 (2 машин) 300л	2,520	756,000
Дүн				1,846,000